

ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж, Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13-т “...Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно...” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, ... амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж, 3.3.1.5-д “Хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлж, энэ чиглэлд институт хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.15-д “Хууль тогтоомжоос үүдэлтэй иргэдийг хохироосон хууль сахиулах байгууллагуудын алдаа гажуудлыг засч, эрх зүйн орчинг нь иргэндээ ойртуулсан, тогтвортой болгох”, мөн хөтөлбөрийн 5.4.11-т “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш шударгаар үйлчилдэг эрх зүйн орчинг цогцоор бүрдүүлэх” зорилтыг тусгасан.

Манай улс НҮБ-ын гишүүн улсын хувьд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, журмыг дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хуульчлан тогтоохдоо Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид заасан суурь зарчимд нийцүүлэх үүрэгтэй.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Монгол Улсад хууль сахиулах буюу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд хүний эрхийг

хязгаарлах, биеийн хүч, албадлага хэрэглэх эрх хэмжээг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалт, хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас гадна тодорхой тохиолдолд байгаль хамгаалагч, улсын байцаагч зэрэг субъект хэрэгжүүлдэг.

Дээрхи субъектүүдийн үйл ажиллагааны үндэсийг Цагдаагийн албаны тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай, Гүйцэтгэх ажлын тухай хууль зэрэг хуулиар тус тусад нь тогтоож, хэрэгжүүлэх журмыг тухайлсан байгууллагын даргын баталсан журмаар харилцан адилгүй зохицуулж байна.

Энэ нь хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг бий болгож, улмаар хууль сахиулах үйл ажиллагааг харилцан адилгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн хүний эрхийг хязгаарлах үндэслэл, журмыг байгууллагын даргын эрх хэмжээний хүрээнд тогтоож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, журмыг зөвхөн хуулиар тогтоох зарчмыг алдагдуулж байна.

Хууль сахиулах тодорхой ажиллагааг гүйцэтгэх эрх бүхий субъект нь хүний эрхийг хязгаарлах тэр дундаа хүч, албадлага хэрэглэх онцгой эрхтэй байдаг. Олон Улсын хүний эрхийн стандартад хууль сахиулагч хүчийг гарцаагүй нөхцөлд эцсийн арга болгон тохирсон хэм хэмжээнд бүрэн хяналтын дор хэрэглэх¹, ийнхүү хэрэглэхдээ хамгаалах аргад суурилах зарчмыг заасан байдаг.

Харин манай улсын хувьд хууль сахиулагчийн хүч, албадлага хэрэглэх эрх хэмжээг хэт ерөнхий байдлаар хуульчилсан төдийгүй үндэслэлийг харилцан адилгүй байдлаар өөр өөр хуулиар² тогтоож, хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурор болон тухайн байгууллагын дарга хамтран баталсан тус тусын журмаар³ зохицуулж байна.

Иймд дээрх хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагын хүрээнд хууль сахиулах байгуулагуудаас нийтлэгээр хэрэгжүүлдэг эрх хэмжээг зөвхөн хуульд заасан үндэслэл, арга хэрэгсэл, журмын дагуу хэрэгжүүлэх зохицуулалтыг хүний эрхийн стандартад нийцүүлэн Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

¹ Хууль сахиулагчийн зан үйлийн дүрэм - Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны 34/169А тоот тогтоол.

Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчим. НҮБ-ын 8 дугаар Их хурал. 1990-8-27.

² Хууль сахиулагчийн “Галт зэвсэг” хэрэглэх эрх хэмжээг 8 хуулиар, “Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх” эрх хэмжээ, үндэслэлийг 10 орчим хуулиар салангид зохицуулж байна. *Ажлын хэсгээс хийсэн судалгаа. 2015 он.*

³ Тухайн журмыг Улсын ерөнхий прокурор болон тухайн байгууллагын дарга хамтран, эсхүл тухайн байгууллагын дарга нь Төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан, Улсын ерөнхий прокурор зөвшилцөн батлахаар хуульчилсан байна. *Ажлын хэсгээс хийсэн судалгаа. 2015 он.*

Энэхүү хуулиар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор эрх бүхий байгууллагуудаас нийтлэг хэрэгжүүлдэг хүний эрхийг хөндөж, хязгаарлах ажиллагааны үндэслэл, журмыг тогтоох, энэхүү ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хуулийн төсөлд дараахь зохицуулалтыг тусгана:

1.Хууль сахиулах ажиллагааны зорилго, хүрээг тодорхойлж, хууль сахиулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, тэдгээрийн эрх хэмжээг зааглан тодорхойлж, хууль сахиулах ажиллагааны оролцогчдыг буюу иргэдийг мэдээллээр хангах, эрхээ эдлэх баталгааг хуульчлах;

2.Хууль сахиулах ажиллагааны төрлийг нарийвчлан тогтоож, хэрэгжүүлэх үндэслэл, журмыг нэгтгэн журамлан хууль тэгш, ялгамжгүй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх;

3.Хууль сахиулах ажиллагаанд орчин үеийн теник, технологийн дэвшлийг ашиглах боломжийг бүрдүүлж, цаг хугацаа, хүний нөөцийг хэмнэх, хяналтын төхөөрөмжийн баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх зохицуулалтыг тусгах;

4.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нууцаар явуулах хууль сахиулах ажиллагааны үндэслэл, журам, хяналтыг тодорхойлж, эдгээр ажиллагааны явцад хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх;

5.Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хүний эрхэд суурилсан, нийгмийн хэрэгцээ, ашиг сонирхолд нийцсэн аргаар хэрэгжүүлэх журмыг тогтоох;

6.Хууль сахиулах ажиллагааны явцад хүч, албадлага хэрэглэх эрх бүхий субьектүүдийн эрх хэмжээг зааглан тогтоож, зөвхөн гарцаагүй байдалд, үүргээ биелүүлэхэд шаардагдсан хэмжээнд тусгай хэрэгсэл, хүч хэрэглэх нь эцсийн арга хэмжээ байх зарчимд нийцүүлэн үндэслэл, журмыг нэгтгэн тогтоох.

Гурав.Хуулийн төсөл батлагдсантай холбоотой үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хууль сахиулах ажиллагааны үндэслэл, журмыг хуулиар нарийвчлан, нэгдсэн стандартаар зохицуулах нь эрх зүйт төр, хүмүүнлэг ардчилсан нийгмийг бэхжүүлэх үйлсэд томоохон хувь нэмэр болно.

Хууль батлагдсаны дараа хэрэгжүүлэхтэй холбоотой улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцүүлэхээс гадна Цагдаагийн албаны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай зэрэг хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдтэй нийцүүлэн боловсруулна.

Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан Гүйцэтгэх ажлын тухай, Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна. Мөн хуулийн төслөөр хууль сахиулах ажиллагааны явцад галт зэвсэг, тусгай хэрэгсэл, хүч хэрэглэх журмыг нэгтгэн зохицуулсантай холбогдуулан Гаалийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай, Төрийн хамгаалалттай газар нутгийн тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

-oOo-